



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/13/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	төгрөгөөр .. 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	төгрөгөөр .. 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	төгрөгөөр.. 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	төгрөгөөр... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	төгрөгөөр .. 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.18 № 2/50

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:\alban bichig\A4.docx

005020324


үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the title 'ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР' (Auditor General) and the name 'Б.МӨНХБАТ' (B. Mönkhbat). The signature is a stylized cursive script.

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,887,268.60</u>	<u>58,838,776.60</u>
33	АВЛАГА	9,885,000.00	00.00
335	Бусад авлага	9,885,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	9,885,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,002,268.60	58,838,776.60
354	Хангамжийн материал	52,002,268.60	58,838,776.60
35410	Бичиг хэргийн материал	786,000.00	598,500.00
35420	Аж ахуйн материал	3,259,130.00	3,051,500.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	450,000.00
35460	Хүнсний материал	55,012.00	3,524.00
35470	Бусад хангамжийн материал	47,902,126.60	54,735,252.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>508,670,279.39</u>	<u>477,929,607.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	508,670,279.39	477,929,607.56
392	Биет хөрөнгө	497,814,279.39	467,073,607.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	457,941,483.96	454,391,414.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-59,884,297.89	-86,479,738.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,423,176.00	34,308,176.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,773,749.97	-10,774,960.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,499,826.80	75,178,926.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,571,458.73	-24,238,245.39
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,461,028.30	69,712,430.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-89,203,627.43	-62,680,463.64
39217	Ном	15,921,898.35	17,656,068.35
393	Биет бус хөрөнгө	10,856,000.00	10,856,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,856,000.00	10,856,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>570,557,547.99</u>	<u>536,768,384.16</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>570,557,547.99</u>	<u>536,768,384.16</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	570,557,547.99	536,768,384.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,535,590.06	434,535,590.06
51101	Өмч: - төрийн	434,535,590.06	434,535,590.06
512	Хуримтлагдсан үр дүн	-113,303,508.20	-147,092,672.03
51210	Өмнөх үеийн үр дүн	-113,303,508.20	-113,303,508.20
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-33,789,163.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	249,325,466.13	249,325,466.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>570,557,547.99</u>	<u>536,768,384.16</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	537,750,130.00	511,603,598.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,523,386.00	8,138,495.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,523,386.00	8,138,495.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,523,386.00	8,138,495.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,523,386.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	6,919,170.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	00.00	1,219,325.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,345,644.00	95,458,003.13
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	472,881,100.00	408,007,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	472,881,100.00	408,007,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,395,644.00	47,922,806.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,395,644.00	47,922,806.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,950,000.00	47,535,197.13
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,950,000.00	47,535,197.13
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	552,678,363.58	543,972,734.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,678,363.58	543,972,734.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,033,323.58	466,992,287.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,356,893.00	303,189,965.00
210101	Үндсэн цалин	298,157,132.00	261,467,040.00
210102	Нэмэгдэл	00.00	19,482,056.00
210104	Урамшуулал	00.00	22,240,869.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,199,761.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,294,859.00	39,370,644.98
210201	Тэтгэврийн даатгал	31,275,795.00	27,831,863.94
210202	Тэтгэмжийн даатгал	3,124,994.00	2,940,856.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,499,997.00	2,437,154.62
210204	Ажилгүйдлийн даатгал	581,280.00	490,771.42
210205	Эрүүл мэндийн даатгал	5,812,793.00	5,669,998.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,692,562.00	43,535,907.13
210301	Гэрэл, цахилгаан	2,576,162.00	1,742,795.13
210302	Түлш, халаалт	32,316,200.00	41,073,112.00
210303	Цэвэр, бохир ус	800,200.00	720,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,660,879.80	13,594,958.00
210401	Бичиг хэрэг	1,593,092.00	1,703,309.00
210402	Тээвэр, шатахуун	1,743,360.00	998,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	144,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,107,910.00	8,888,870.00
210408	Бараа материал акталсны зардал	14,066,517.80	1,860,199.00
2105	Нормативт зардал	11,442,414.00	7,363,088.00



Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	11,358,414.00	7,363,088.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	84,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	4,257,710.00
210604	Урсгал засвар	00.00	4,257,710.00
2107	Томилолт, зочны зардал	1,180,500.00	248,700.00
210702	Дотоод албан томилолт	1,180,500.00	248,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,500.00	793,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	93,500.00	443,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,311,715.78	54,638,313.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	173,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,311,715.78	54,464,813.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,645,040.00	76,980,447.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,383,944.00	53,008,697.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,758,300.00	8,692,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,023,547.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,395,644.00	4,533,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,230,000.00	759,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,104,538.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,104,538.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,156,558.00	23,971,750.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,156,558.00	23,971,750.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-14,928,233.58	-32,369,135.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,420,027.89
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,420,027.89
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,420,027.89
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-14,928,233.58	-33,789,163.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	519,226,744.00	503,465,103.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	519,226,744.00	503,465,103.13
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	472,881,100.00	408,007,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,395,644.00	47,922,806.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,395,644.00	47,922,806.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,950,000.00	47,535,197.13
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,950,000.00	47,535,197.13

Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	505,351,744.00	495,125,103.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,351,744.00	495,125,103.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,717,504.00	419,620,756.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,356,893.00	302,843,397.98
210101	Үндсэн цалин	220,609,579.36	227,144,097.00
210102	Нэмэгдэл	46,955,536.64	51,475,312.98
210104	Урамшуулал	31,221,077.00	24,223,988.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,570,700.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,294,859.00	39,717,212.00
210201	Тэтгэврийн даатгал	31,443,300.00	29,918,524.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,922,559.00	2,449,596.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,647,700.00	1,959,897.54
210204	Ажилгүйдлийн даатгал	661,900.00	489,899.39
210205	Эрүүл мэндийн даатгал	6,619,400.00	4,899,293.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,362,562.00	43,535,907.13
210301	Гэрэл, цахилгаан	2,576,162.00	1,742,795.13
210302	Түлш, халаалт	27,986,200.00	41,073,112.00
210303	Цэвэр, бохир ус	800,200.00	720,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,368,110.00	6,343,440.00
210401	Бичиг хэрэг	1,064,100.00	997,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,743,360.00	998,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	144,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,410,650.00	4,202,960.00
2105	Нормативт зардал	10,723,180.00	12,073,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	921,200.00	25,000.00
210502	Хоол, хүнс	9,801,980.00	8,766,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,281,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	482,900.00	4,940,490.00
210604	Урсгал засвар	482,900.00	4,940,490.00
2107	Томилолт, зочны зардал	1,180,500.00	248,700.00
210702	Дотоод албан томилолт	1,180,500.00	248,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,500.00	4,858,609.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	93,500.00	4,508,609.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,855,000.00	5,059,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,855,000.00	959,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,634,240.00	75,504,347.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,373,144.00	51,532,597.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,747,500.00	7,216,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,023,547.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,395,644.00	4,533,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,230,000.00	759,000.00

Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,104,538.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,104,538.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,156,558.00	23,971,750.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,156,558.00	23,971,750.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,875,000.00	8,340,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,875,000.00	8,340,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,875,000.00	8,340,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,875,000.00	8,340,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,875,000.00	8,340,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,875,000.00	-8,340,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	-81,706,157.10	602,154,899.09
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	-81,706,157.10	602,154,899.09
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	-113,303,508.20	570,557,547.99
D01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	-113,303,508.20	570,557,547.99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	-113,303,508.20	570,557,547.99
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-33,789,163.83	-33,789,163.83
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,535,590.06	249,325,466.13	-147,092,672.03	536,768,384.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	455,620,900.00	431,570,547.11	24,050,352.89	94.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	455,620,900.00	431,570,547.11	24,050,352.89	94.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	443,012,500.00	423,595,147.11	19,417,352.89	95.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,993,600.00	302,843,397.98	8,150,202.02	97.38
210101	Үндсэн цалин	231,922,300.00	227,144,097.00	4,778,203.00	97.94
210102	Нэмэгдэл	53,442,300.00	51,475,312.98	1,966,987.02	96.32

Баянхонгор сумын Шаргалжуут 8-р багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	455,620,900.00	431,570,547.11	24,050,352.89	94.72
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	408,007,100.00	384,035,349.98	23,971,750.02	94.12
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	408,007,100.00	384,035,349.98	23,971,750.02	94.12
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,613,800.00	47,535,197.13	78,602.87	99.83
132001	Орон нутгийн төсвөөс	47,613,800.00	47,535,197.13	78,602.87	99.83
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30.00	30.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	171.00	171.00	0.00	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	170.00	170.00	0.00	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	170.00	170.00	0.00	100.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	01.00	01.00	0.00	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	01.00	01.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30.00	30.00	0.00	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,395,644.00	47,922,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,395,644.00	47,922,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,395,644.00	47,922,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,395,644.00	4,365,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,395,644.00	4,365,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,395,644.00	43,557,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,395,644.00	43,557,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	39,023,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	4,533,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,395,644.00	47,922,806.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,395,644.00	47,922,806.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,395,644.00	47,922,806.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд сургуулийн захирал Н.Амарсанаа нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Б.Одгэрэл хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээр алдаагүй зөв цэвэр сайхан бичдэг, өөрийгөө илэрхийлэх чадвартай, мэндлэх, хүндлэх ёсыг дээдэлдэг цэвэр нямбай хүүхэд төлөвшүүлнэ” гэсэн зорилготой ажиллаж байна.

- Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын

Шаргалжуут 8 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 569,347.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,540.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6,832.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 8,159.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдал 6,527.7 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 536,768.3 мянган төгрөг болж өмнөх оноос 33,789.2 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,887.20	58,838.70	-3,048.50
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	9885.0	0	-9,885.00
Урьдчилгаа	-	-	0.00
Бараа материал	52,002.20	58,838.70	6,836.50
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	508,670.20	477,929.60	-30,740.60
Үндсэн хөрөнгө	678,103.40	662,103.00	-16,000.40
Хуримтлагдсан элэгдэл	-169,433.10	-184,173.40	-14,740.30
Нийт хөрөнгө	570,557.50	536,768.30	-33,789.20
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	570,557.50	536,768.30	-33,789.20
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	570,557.50	536,768.30	-33,789.20

Бараа материалын дансны үлдэгдэл 58,838.7 мянган төгрөг болж 6,836.5 мянган төгрөгөөр өссөн нь түлш, шатах тослох материалын үлдэгдэл өмнөх оноос 450.0 мянган төгрөг, бусад хангамжийн материалын үлдэгдэл 6,833.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба БСШУЯ-наас 247.5 мянган төгрөгийн эмийн багц, БСУГ-аас 134.5 мянган төгрөгийн ариутгалын бодис, аймгийн ЗДТГ-аас шилжүүлж ирсэн 887.3 мянган төгрөгийн хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх тогтоол тус тус хүлээн авч орлогоор бүртгэсэн нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 662,103.0 мянган төгрөг болж 16,000.4 мянган төгрөгөөр буурсан 41,144.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 156 тоот тогтоолын дагуу акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 536,768.3 мянган төгрөг болж 33,789.2 мянган төгрөгөөр буурсан тайлант үеийн үр дүн (33,789.1) мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 642,882.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 126,003.5 мянган төгрөгөөр бууруулж 516,878.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 455,620.9 мянган төгрөг болж 61,257.8 мянган төгрөг буюу 13.4 хувиар буурч батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 455,620.9 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 408,007.1 мянга, орон нутгийн төсвөөс 47,613.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 408,007.1 мянга, орон нутгийн төсвөөс 47,613.8 мянга нийт 455,620.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 431,570.5 мянган төгрөгийг зарцуулж 24,050.3 мянган төгрөг буюу 5.5 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харин орон нутгийн төсвийн санхүүжилтийг 78.6 мянган төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу санхүүжүүлсэн байгаа нь төсвийг гүйцэтгэлтэй нь уялдуулан олгосонтой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 431,570.5 мянган төгрөг буюу 94.7 хувьтай байгаа нь цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардал 8,150.2 мянга, норматив зардал 6,595.8 мянга, хангамжийн материалын зардал 1,158.0 мянга, бараа үйлчилгээний зардал 1,593.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100032015404 тоот дансанд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж, урамшууллын зардалд 4,533.6 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 39,023.5 мянга, Тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилт 4,300.0 мянга, түвшин тогтоох шалгалтын бичиг хэргийн зардалд 65.6 мянга нийт 47,922.7 мянган төгрөгийг олгосныг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Ганчимэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 44 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 85%-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 543,972.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 8,705.6 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамжийн материал өмнөх оноос буурсан бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 455,620.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 455,620.1 мянган төгрөгийн Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт бүтэн жилээр мэдээлэх 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	95	1	0
	Нийт	27	151	148	1	2

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 408,007.1 мянга, орон нутгийн төсвөөс 47,613.8 мянга нийт 455,620.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 431,570.5 мянган төгрөгийг зарцуулж 24,050.3 мянган төгрөг буюу 5.5 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд тогтмол зардалд 43,613.8 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 8,722.7 мянган төгрөг байна. Тус онд 78.6 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 8,644.1 мянган төгрөгийн хэмнэлт үүсгээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9,885.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 заалт бүхий зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021 оны 06 дүгээр сарын 14-ны өдрийн 53 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 10,157.3 мянган төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Зөвлөмж

4.1.1 Тайлант онд тогтмол зардалд 43,613.8 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 8,722.7 мянган төгрөг байна. Тус онд 78.6 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 8,644.1 мянган төгрөгийн хэмнэлт үүсгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид Засгийн газрын тогтоол болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах.

4.1.2 Тайлант онд 1,513.2 төгрөгийн 5 нэр төрлийн ном орлогд авахдаа тоо ширхэг бүрээр салгахгүй бөөн дүнгээр орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4 “Үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Бөөн дүнгээр орлогоор бүртгэсэн 5 нэр төрлийн 1,513.2 мянган төгрөгийн номыг тоо ширхэг бүрээр салгаж бүртгэл тайланд тусгах зөвлөмж өгөх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 8-р багийн Ерөнхий боловсролын сургууль	2	10,157.3	0	0	0	0	0	0	2	10,157.3

_____оОо_____